| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                                                                                    |               |                     |
| 210604      | Урсгал засвар                                                                                                   | 2,000,000.00  |                     |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                                                                   | 700,000.00    | 818,000.00          |
| 210701      | Гадаад албан томилолт                                                                                           |               |                     |
| 210702      | Дотоод албан томилолт                                                                                           | 700,000.00    | 818,000.00          |
| 210703      | Зочин төлөөлөгч хүлээн авах                                                                                     |               |                     |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                                                          | 16,500,000.00 | -                   |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                                                                 | 16,500,000.00 |                     |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                                                               |               |                     |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                                                         | -             | -                   |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                                                                            | -             | <b>1,550,000.00</b> |
| 213303      | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг                                                         |               |                     |
| 213403      | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг                                 |               |                     |
| 213503      | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг                                                  |               | 1,550,000.00        |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                                           | 22,379,600.00 | 6,508,093.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                              | 22,379,600.00 | 6,508,093.00        |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж                                             |               |                     |
| 131102      | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл |               |                     |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө     |               |                     |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө      | 22,379,600.00 | 6,508,093.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                    |               |                     |
| 131106      | Төсвийн урамшуулал                                                                                              |               |                     |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>                                                                 |               |                     |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                                                                |               |                     |

|  |                                                      |  |  |
|--|------------------------------------------------------|--|--|
|  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн<br>үлдэгдэл |  |  |
|--|------------------------------------------------------|--|--|

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар нь төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага.

Засаг даргын тамгын газрын тайлант оны зорилгыг “Удирдлагын орчин үеийн дэвшилттэй арга барил, туршлагыг нэвтрүүлэн, төрийн албаны ажилтны мэдлэг, чадварыг ахиулж, төрийн байгууллагын чадавхыг дээшлүүлэх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих, хуулийн хүрээнд ажиллах” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- “Төрийн үйлчилгээг ард иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэх, хууль тогтоомжийг хүргэж ойлгуулах, төсвийг зүй зохистой зарцуулах, ил тод болгох”

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны 09 дүгээр сард баримтын шалгалт хийсэн байна. Шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй байна.

Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 11 сарын 20-ны өдрийн 02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.5 сая төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн байна.

#### **Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                         | Эхний үлдэгдэл    | Эцсийн үлдэгдэл   | Өөрчлөлт |
|--------------------------------------------------|-------------------|-------------------|----------|
| Б                                                | 1                 | 2                 | 3=2-1    |
| Мөнгөн хөрөнгө                                   | -                 | -                 |          |
| Авлага                                           | 2,692.30          | 2,692.30          | 0        |
| Урьдчилгаа                                       | -                 | -                 |          |
| Бараа материал                                   | 3,038.60          | 3,126.10          | -87.5    |
| Үндсэн хөрөнгө                                   | 644,888.80        | 668,312.00        | -23423.2 |
| <b>Нийт хөрөнгө</b>                              | <b>650,619.70</b> | <b>674,130.40</b> | -23510.7 |
| Өр төлбөр                                        | 19,285.30         | 7,754.90          | 11530.4  |
| Засгийн газрын хувь оролцоо<br>/Эздийн өмч/      | 631,334.30        | 666,375.50        | -35041.2 |
| <b>Өр төлбөр ба цэвэр<br/>хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>650,619.60</b> | <b>674,130.40</b> | -23510.8 |

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө, өглөг дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Засаг даргын тамгын газар нь оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 7.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үндсэн санхүүжилтийн дүнгээс 5.8 сая төгрөгийг, нэмэлт санхүүжилтийн дүнгээс 1.5 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Он эхэнд байсан 2.9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Бараа материалын үлдэгдэл 0.1 сая төгрөгөөр нэмэгдсэн.Төсвийн хөрөнгөөр 82.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 82.1 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 3.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.Акталсан, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 23.4 сая төгрөгөөр өссөн. ОНХС-ийн болон бусад эх үүсвэрээр нийт 79.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг, тооллогоор илэрсэн 4.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна. Холбогдох байгууллагын шийдвэрээр 19.9 сая төгрөгийн авто тээврийн хэрэгслийг шилжүүлж, 17.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан. Үндсэн хөрөнгөд 55.8 сая төгрөгийн элэгдэл байгуулж, шилжүүлсэн буюу акталсан үндсэн хөрөнгийн 37.0 сая төгрөгийн элэгдлийг бүртгэлээс хассан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 35.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 388.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 388.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 210.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 599.8 сая төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна.Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 599.8 сая сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 599.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 594.1 сая төгрөг буюу 99.0 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| /мянган төгрөгөөр/ |                                             |            |            |        |         |
|--------------------|---------------------------------------------|------------|------------|--------|---------|
| д/д                | Хөтөлбөр, арга хэмжээ                       | Төлөвлөгөө | Гүйцэтгэл  | Зөрүү  | Биелэлт |
|                    | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага |            |            |        |         |
| 80101              | Үндсэн үйл ажиллагааны орлого               | 431,551.20 | 430,849.80 | 701.40 | 99.84%  |

|       |                                          |                   |                   |                 |               |
|-------|------------------------------------------|-------------------|-------------------|-----------------|---------------|
| 80102 | Туслах үйл ажиллагааны зардал            | 89,661.90         | 89,636.90         | 25.00           | 99.97%        |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 70,279.90         | 70,279.90         | 0.00            | 100.00%       |
| 81701 | Байгаль хамгаалах, нөхөн сэргээх         | 8,370.00          | 3,288.50          | 5,081.50        | 39.29%        |
|       | <b>Дүн</b>                               | <b>599,863.00</b> | <b>594,055.10</b> | <b>2,770.80</b> | <b>99.30%</b> |

Үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрөөс 0.7 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны хөтөлбөрөөс 0.02 сая төгрөгийг, байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрөөс 5.1 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрт 3.3 сая төгрөгийг зарцуулж, хөтөлбөрийн хэрэгжилт 39.3 хувьтай бөгөөд 5.1 сая төгрөгийн төсөв нь оны эцэст тулж орж ирсэн тул зарцуулж амжаагүй төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар нь 6.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 5.0 сая төгрөгийг зарцуулсан. Үүнд: урамшуулалд 0.7 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 3.4 сая төгрөгийг, шуудан холбооны зардалд 0.8 сая төгрөгийг тус тус зарцуулж, 1.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө бэлтгээгүй байна. Халаалтын зардлыг “Киели жүйрик” ХХК-наас худалдан авсан боловч гэрээг 2018 оноос хойш шинэчлээгүй, шатахууныг “Жасхайрат”, “Гүлчингис” хоршооноос худалдаж авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 3/18 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 445.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 650.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.7 сая төгрөг болж байна.

Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Сумд 1 орлогч дарга ажилласан. Тээврийн хэрэгслийг сум дотор ашиглаагүй, аймагт болон хөдөө ажиллахад ашигласан байна. Төсвийн хөрөнгөөр хөрөнгө бэлтгээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байгууллагын албаны хэрэгцээнд ашиглаж буй УАЗ 469 маркийн 0075 БӨТ улсын дугаар бүхий машин нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө

бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж улсын дугаарыг өөрчлөөгүй<sup>1</sup> зөрчил байна.

Шийдвэрлэсэн нь: Албаны хэрэгцээнд ашиглаж буй УАЗ 469 маркийн улсын 0075 БӨТ дугаарыг бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солихыг зөвлөмж болгов.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 69.8 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 85.2 хувьтай байна. Хугацаа хоцроож оруулсан мэдээлэл байхгүй.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 69.8 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй зөрчилд зөвлөмж өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Засаг даргын тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн. Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан. Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шилэн дансны цахим хуудсанд төсөв, мөнгө, хөрөнгө зарцуулсантай холбоотой гарсан 9 тушаал шийдвэрийг байршуулаагүй байсан зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж цахим хуудсанд нөхөн байршуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт |     | Биелэлт |     |      |
|----------|------------------------|-----|---------|-----|------|
|          | Тоо                    | Дүн | Тоо     | Дүн | Хувь |

|                 |          |          |          |          |            |
|-----------------|----------|----------|----------|----------|------------|
| Акт             |          |          |          |          |            |
| Албан шаардлага |          |          |          |          |            |
| Зөвлөмж         | 1        | 0        | 1        | 0        | 100        |
| <b>Нийт дүн</b> | <b>1</b> | <b>0</b> | <b>1</b> | <b>0</b> | <b>100</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,254.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 36,254.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа. *Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд эх үүсвэрээс 5,808.0 мянган төгрөгийн төвлөрүүлсэн орлогыг цэвэрлээгүй, Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,550.0 мянган төгрөгийг нийт зардалд оруулж тайлагнасныг залруулав.
- Мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд дээд шатны төсвийн захирагчаас болон бусад орлогод тайлагнасан нийт 6,508.1 мянган төгрөгийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогод оруулж тайлагнасныг залруулав.
- Санхүүгийн байдлын тайланд ажиллагсадтай холбоотой үүссэн оны эхний 14,903.5 мянган төгрөгийн, оны эцсийн 7,754.9 мянган төгрөгийн өглөгийг байгууллагад төлөх өглөгт тусгасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 123,475.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч, 123,475.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй

#### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй болно.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

##### 1.1.Илрүүлэлт:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Няrvын бараа материалын тайланг сараар гаргаагүй, оны эцсийн 2034.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг баталгаажуулж, тооллого хийгдээгүй, бараа материалын зарцуулалтад тавих хяналтыг сулруулсан.
- Тайлант онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн бүгд 51,641.9 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 14.3.3, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн 20.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

- Бараа материалын тайланг сар бүр гаргуулж тооцоо хийж, үлдэгдлийг тооллогоор баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангах, бараа, ажил үйлчилгээнд төлсөн зардлыг тооцооны дансаар дамжуулан бүртгэж тайлагнах.

### **2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой**

#### 2.1. Илрүүлэлт:

- Байгууллагын УАЗ 469 маркийн улсын 0075 БӨТ дугаар бүхий албаны авто машины улсын дугаарыг өөрчлөөгүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

#### 2.2. Өгсөн зөвлөмж:

- Албаны УАЗ 469 маркийн автомашины улсын 0075 БӨТ дугаарыг бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих.

### **3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

#### 3.1. Илрүүлэлт:

- Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 69.8 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 85.2 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4-т "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4 дэх хэсгийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 7 дугаар зүйлийн 7.1-д "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ" гэсэн заалт, Засгийн

газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

### 3.2. Өгсөн зөвлөмж:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 69.8 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нөхөн байршуулан мэдээлж, зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| /мянган төгрөгөөр/                                      |            |         |                                   |     |                          |         |            |         |              |     |         |     |
|---------------------------------------------------------|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|---------|------------|---------|--------------|-----|---------|-----|
| Алдааны товч утга                                       | Нийт алдаа |         | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |         | Үүнээс     |         |              |     | Зөвлөмж |     |
|                                                         |            |         |                                   |     |                          |         | Залруулсан |         | Залруулаагүй |     |         |     |
|                                                         | Тоо        | Дүн     | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн     | Тоо        | Дүн     | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй | 4          | 36524.5 | 0                                 | 0   | 4                        | 36524.5 | 4          | 36524.5 |              |     |         |     |
|                                                         |            |         |                                   |     |                          |         |            |         |              |     |         |     |
| Дүн                                                     | 4          | 36524.5 | 0                                 | 0   | 4                        | 36524.5 | 4          | 36524.5 |              |     |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга                            | Нийт зөрчил |         | Үүнээс        |     |                 |     |         |         |                                      |                     |                                                 |     |
|-----------------------------------------------|-------------|---------|---------------|-----|-----------------|-----|---------|---------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                                               |             |         | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |         | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                               | Тоо         | Дүн     | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн     | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн | 2           | 53676.5 |               |     |                 |     | 2       | 53676.5 |                                      |                     |                                                 |     |
|                                               |             |         |               |     |                 |     |         |         |                                      |                     |                                                 |     |
| Дүн                                           | 2           | 53676.5 |               |     |                 |     | 2       | 53676.5 |                                      |                     |                                                 |     |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч<br>утга                                             | Нийт зөрчил |                | Үүнээс        |     |                 |     |          |                |
|-------------------------------------------------------------------|-------------|----------------|---------------|-----|-----------------|-----|----------|----------------|
|                                                                   |             |                | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |                |
|                                                                   | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн            |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил          |             |                |               |     |                 |     |          |                |
| Шилэн дансны<br>цахим хуудсан<br>мэдээлээгүй<br>орхигдуулсан      | 1           | 69799.3        |               |     |                 |     | 1        | 69799.3        |
| <b>Дүн</b>                                                        | <b>1</b>    | <b>69799.3</b> |               |     |                 |     | <b>1</b> | <b>69799.3</b> |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил     |             |                |               |     |                 |     |          |                |
| Төрийн<br>хэмнэлтийн<br>тухай хуулийн<br>зарим заалтыг<br>зөрчсөн | 1           | 0              |               |     |                 |     | 1        | 0              |
| <b>Дүн</b>                                                        | <b>1</b>    | <b>0</b>       |               |     |                 |     | <b>1</b> | <b>0</b>       |
| <b>Нийт дүн</b>                                                   | <b>2</b>    | <b>69799.3</b> |               |     |                 |     | <b>2</b> | <b>69799.3</b> |